

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2024/217/НА-СТА-ТШЗ

Чингис хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

Ахлах аудитор Г.Энх-Амгалан  
Утас 91119424 Цахим хаяг: [Enkh-amgalang@audit.gov.mn](mailto:Enkh-amgalang@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Стандарт дүгнэлт аудит  
ХХК Аудитор: Б.Наранцэцэг  
Утас: 99569960 Цахим хаяг: [info@sda-audit.mn](mailto:info@sda-audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2024.02.26 № 214

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын 1,332,364.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 103,040.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, нярав бараа материалын тайлан гаргаагүй зэрэг зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1 дэх заалттай нийцээгүй, мөн цалингийн зардлаас 2,411.5 мянган төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлыг төлж, зардал хооронд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолыг зөрчсөн. Зөрчлийн дүн урьдчилан тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 95,144.1 мянган төгрөг, авлага 273.7 мянган төгрөг, бараа материал 103,834.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 981,772.5 мянган төгрөг, өр төлбөр 1,489.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд улсын төсвөөс 990,523.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 213,750.4 мянган төгрөгөөр санхүүжихээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс

232420245

990,523.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 144,784.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,536.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 6,016.0 мянган төгрөг, нийт 1,143,777.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй, урсгал үйл ажиллагаанд 1,095,359.0 мянган төгрөгийг зарцуулан харилцах дансандаа 95,144.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

### **Аудитын гол асуудал**

Тухайн байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 2 дугаар сарын 22-нд ирүүлсэн нь Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанаас 20 хоног хугацаа хоцроосон, аудит хийхэд саад учруулж байгаад дүгнэлт хийх шаардлагатай байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 71 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, 91.0 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>144,175,907.69</b>	<b>199,252,623.24</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>46,726,335.49</b>	<b>95,144,145.67</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>46,726,335.49</b>	<b>95,144,145.67</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>46,726,335.49</b>	<b>95,144,145.67</b>
31211	Төрийн сангийн харилцах	46,726,335.49	95,144,145.67
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>315,776.58</b>	<b>273,706.25</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	227,776.58	185,706.25
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>88,000.00</b>	<b>88,000.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	88,000.00	88,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>97,133,795.62</b>	<b>103,834,771.32</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>-</b>	<b>794,682.70</b>
35110	Тусгай зориулалттай материал	-	794,682.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>88,393,795.62</b>	<b>97,750,088.62</b>
35410	Бичиг хэргийн материал	2,062,705.64	1,845,805.64
35420	Аж ахуйн материал	16,427,635.00	15,440,635.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	330,000.00
35450	Барилгын засварын материал	4,429,400.00	2,508,490.00
35460	Хүнсний материал	1,328,500.00	1,422,800.00
35470	Бусад хангамжийн материал	64,145,554.98	76,202,357.98
35600	Мал амьтад	8,740,000.00	5,290,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>628,893,163.91</b>	<b>981,772,540.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>628,893,163.91</b>	<b>981,772,540.28</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>579,228,163.91</b>	<b>932,167,540.28</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	585,341,360.00	872,274,331.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(149,112,881.88)	(177,118,152.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,353,802.01	289,460,542.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,346,003.11)	(108,237,882.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,607,426.03	70,945,841.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,348,072.93)	(47,069,377.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,104,310.00	30,104,310.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,611,982.56)	(17,583,524.64)
39217	Ном	18,240,206.35	19,391,453.35
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>49,665,000.00</b>	<b>49,605,000.00</b>
39301	Програм хангамж	922,600.00	922,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(837,600.00)	(897,600.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	49,580,000.00	49,580,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>773,069,071.60</b>	<b>1,181,025,163.52</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>174,499.75</b>	<b>1,489,499.75</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>174,499.75</b>	<b>1,489,499.75</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>174,499.75</b>	<b>1,489,499.75</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>174,499.75</b>	<b>1,489,499.75</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	174,499.75	1,489,499.75
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>772,894,571.85</b>	<b>1,179,535,663.77</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>772,894,571.85</b>	<b>1,179,535,663.77</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	766,199,791.75	766,199,791.75
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(133,813,300.66)</b>	<b>272,827,791.26</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(133,813,300.66)	(133,813,300.66)
51220	Тайлант үеийн үр дүн	-	406,641,091.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	140,508,080.76	140,508,080.76
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>773,069,071.60</b>	<b>1,181,025,163.52</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,797,538,005.19</b>	<b>1,514,993,664.70</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>765,971,205.19</b>	<b>379,685,364.70</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	765,971,205.19	379,685,364.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,195,244.00	8,552,456.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,048,744.00	2,536,456.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,146,500.00	6,016,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	669,035,415.57	366,392,113.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	91,740,545.62	4,740,795.70
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,031,566,800.00</b>	<b>1,135,308,300.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	802,394,600.00	990,523,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	802,394,600.00	990,523,700.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	229,172,200.00	144,784,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	229,172,200.00	144,784,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,027,659,678.48</b>	<b>1,108,352,572.78</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,027,659,678.48</b>	<b>1,108,352,572.78</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	878,530,828.87	1,031,146,896.39
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	562,345,803.38	688,548,472.95
210101	Үндсэн цалин	422,655,492.38	455,729,523.60
210102	Нэмэгдэл	107,808,472.00	183,639,099.58
210104	Урамшуулал	31,881,839.00	49,179,849.77
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,753,677.98	86,130,560.20
210201	Тэтгэврийн даатгал	47,549,481.34	58,669,170.50
210202	Тэтгэмжийн даатгал	5,623,327.62	6,902,255.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,481,862.20	5,482,435.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,099,910.64	1,370,608.80
210205	Эрүүл мэндийн даатгал	10,999,096.18	13,706,089.70
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	134,526,217.71	140,740,004.61
210301	Гэрэл, цахилгаан	8,037,057.71	7,363,124.61
210302	Түлш, халаалт	123,609,160.00	130,526,880.00
210303	Цэвэр, бохир ус	2,880,000.00	2,850,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	253,700.00	589,100.00
210401	Бичиг хэрэг	-	589,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	253,700.00	-
2105	<b>Нормативт зардал</b>	17,478,065.00	15,425,639.00
210502	Хоол, хүнс	17,478,065.00	15,425,639.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,624,100.00	2,827,285.00
210604	Урсгал засвар	4,624,100.00	2,827,285.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,010,000.00	12,030,440.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,190,000.00	7,010,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,820,000.00	5,020,440.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	83,539,264.80	84,855,394.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,350,230.00	29,534,514.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,878,800.00	7,844,010.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,310,234.80	47,476,870.63
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	149,128,849.61	77,205,676.39
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	77,505,260.00	77,122,154.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,690,360.00	52,490,554.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,814,900.00	24,631,600.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	71,623,589.61	83,522.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,623,589.61	83,522.39
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>769,878,326.71</b>	<b>406,641,091.92</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>769,878,326.71</b>	<b>406,641,091.92</b>

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,036,762,044.00</b>	<b>1,143,860,756.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,195,244.00</b>	<b>8,552,456.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,195,244.00</b>	<b>8,552,456.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,048,744.00	2,536,456.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,146,500.00	6,016,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>1,031,566,800.00</b>	<b>1,135,308,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>802,394,600.00</b>	<b>990,523,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	802,394,600.00	990,523,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>229,172,200.00</b>	<b>144,784,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	229,172,200.00	144,784,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>977,920,708.51</b>	<b>1,061,305,685.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>827,993,058.90</b>	<b>983,396,959.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>560,721,872.60</b>	<b>688,373,651.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>427,349,121.26</b>	<b>455,549,517.60</b>
210101	Үндсэн цалин	101,490,913.00	183,644,284.14
210102	Нэмэгдэл	31,881,838.34	49,179,849.77
210104	Урамшуулал	<b>69,502,123.34</b>	<b>86,263,311.31</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,297,927.81</b>	<b>58,482,029.28</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,623,327.62	6,924,545.66
210202	Тэтгэмжийн даатгал	4,481,862.20	5,869,232.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,099,909.53	1,363,457.46
210204	Ажилгүйдлийн даатгал	10,999,096.18	13,624,045.98
210205	Эрүүл мэндийн даатгал	<b>134,526,217.71</b>	<b>140,740,004.61</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>8,037,057.71</b>	<b>7,363,124.61</b>
210301	Гэрэл, цахилгаан	123,609,160.00	130,526,880.00
210302	Түлц, халаалт	2,880,000.00	2,850,000.00
210303	Цэвэр, бохир ус	<b>412,300.00</b>	<b>-</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>412,300.00</b>	<b>-</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	<b>17,656,065.25</b>	<b>14,804,589.00</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,656,065.25</b>	<b>14,804,589.00</b>
210502	Хоол, хүнс	<b>2,104,400.00</b>	<b>3,961,073.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,104,400.00</b>	<b>3,961,073.00</b>
210604	Урсгал засвар	<b>6,143,880.00</b>	<b>10,342,440.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,558,200.00</b>	<b>4,027,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,585,680.00	6,315,440.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	<b>36,926,200.00</b>	<b>38,911,890.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,382,000.00</b>	<b>29,438,190.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,544,200.00	9,473,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	<b>149,927,649.61</b>	<b>77,908,726.39</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,304,060.00</b>	<b>77,825,204.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	53,489,160.00	53,193,604.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,814,900.00	24,631,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	<b>71,623,589.61</b>	<b>83,522.39</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>71,623,589.61</b>	<b>83,522.39</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	<b>58,841,335.49</b>	<b>82,555,070.18</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>12,115,000.00</b>	<b>34,137,260.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>12,115,000.00</b>	<b>34,137,260.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,115,000.00</b>	<b>34,137,260.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>12,115,000.00</b>	<b>34,137,260.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	<b>(12,115,000.00)</b>	<b>(34,137,260.00)</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>46,726,335.49</b>	<b>48,417,810.18</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>46,726,335.49</b>	<b>46,726,335.49</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>46,726,335.49</b>	<b>95,144,145.67</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>46,726,335.49</b>	<b>95,144,145.67</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	766,199,791.75	140,508,080.76	(133,986,426.66)	772,721,445.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	406,641,091.92	406,641,091.92
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	766,199,791.75	140,508,080.76	272,654,665.26	1,179,362,537.77

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,262,871,200.00</b>	<b>1,095,359,423.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,262,871,200.00</b>	<b>1,095,359,423.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,173,068,300.00</b>	<b>1,017,534,219.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>762,274,000.00</b>	<b>688,373,651.51</b>
210101	Үндсэн цалин	505,589,100.00	455,549,517.60
210102	Нэмэгдэл	204,749,300.00	183,644,284.14
210104	Урамшуулал	51,935,600.00	49,179,849.77
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>95,284,200.00</b>	<b>86,263,311.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,793,300.00	58,482,029.28
210202	Тэтгэмжийн даатгал	7,622,800.00	6,924,545.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,098,100.00	5,869,232.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,500.00	1,363,457.46
210205	Эрүүл мэндийн даатгал	15,245,500.00	13,624,045.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>209,750,400.00</b>	<b>140,740,004.61</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,765,000.00	7,363,124.61
210302	Түлш, халаалт	190,685,400.00	130,526,880.00
210303	Цэвэр, бохир ус	6,300,000.00	2,850,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,991,200.00</b>	<b>14,804,589.00</b>
210502	Хоол, хүнс	14,991,200.00	14,804,589.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,000,000.00</b>	<b>3,961,073.00</b>
210604	Урсгал засвар	4,000,000.00	3,961,073.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,676,900.00</b>	<b>10,342,440.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,361,100.00	4,027,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,315,800.00	6,315,440.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>75,091,600.00</b>	<b>73,049,150.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,617,900.00	63,575,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,473,700.00	9,473,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>89,802,900.00</b>	<b>77,825,204.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>89,802,900.00</b>	<b>77,825,204.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	65,171,300.00	53,193,604.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,631,600.00	24,631,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,262,871,200.00</b>	<b>1,143,777,233.61</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>990,523,700.00</b>	<b>990,523,700.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	990,523,700.00	990,523,700.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>213,750,400.00</b>	<b>144,701,077.61</b>
132001	Орон нутгийн төсвөөс	213,750,400.00	144,701,077.61
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>58,597,100.00</b>	<b>8,552,456.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,870,500.00	2,536,456.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	6,016,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	46,726,600.00	46,726,335.49
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>95,144,145.67</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 1,347,815.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 албан шаардлага өгч, хариуцлага тооцох саналыг хүргүүлэв.

#### 3.1 Төлбөрийн акт

Байхгүй

#### 3.2 Албан шаардлага

1. Санхүүгийн тайланд тусгагдсан 1,332,364.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 103,040.1 мянган төгрөгийн бараа материалд тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, няравын бараа материалын тайлан гаргаагүй байна.

2. Цалингийн зардлаас 2,411.5 мянган төгрөгийн ажил олгогчийн шимтгэлийн зардлыг төлж, зардал хооронд гүйлгэн зарцуулсан.

3. Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн хуульд заасан цаглабарт хугацаанд ирүүлээгүй тул сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.3 Зөвлөмж

Байхгүй

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөрөнгийн тооллого хийгээгүй	1	1,435,404.2			1	1,435,404.2						
Цалингийн зардлаас НДШ төлсөн	1	2,411.5			1	2,411.5						
Санхүүгийн тайлан хугацаанд нь ирүүлээгүй	1									1		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,437,815.7</b>			<b>2</b>	<b>1,437,815.7</b>				<b>1</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 26

Дугаар 60-179250-43

Чингис хот

ХАА-2024/917/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 1,332,364.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 103,040.1 мянган төгрөгийн бараа материалд тооллогыг хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, нярвын бараа материалын тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийг тоолдоггүй, баталгаажуулдаггүй, бараа материалын тайлан гаргадаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сургуулийн захирлын үүргийн түр орлон гүйцэтгэгч Г.Төмөрбаатар, нягтлан бодогч Г.Урансүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

"СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ"  
ХХК-ИЙН АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ

232440180



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 26

Дугаар 64/17925043

Чингис хот

ХТА-2024/217/НА-СТА-ТЦУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас 2,411.5 мянган төгрөгийн ажил олгогчийн шимтгэлийн зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл.Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх. 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Цалингийн зардлаас ажил олгогчийн шимтгэлийн зардлыг төлдөг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сургуулийн захирлын үүргийн түр орлон гүйцэтгэгч Г.Төмөрбаатар, нягтлан бодогч Г.Урансүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

“СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ”  
ХХК-ИЙН АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.НАРАНЦЭЦЭГ

232440183



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 04

Дугаар 42/14925043  
ХТН-2024/277/НА-СТА-ТМЗ

Чингис хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 29 хоног хугацаа хоцроон ирүүлж, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-д "Төсвийн шууд захирагч .....жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Төрийн аудитын тухай хуулийн 16.1.1-д "Төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, .....аудитын үйл ажиллагаанд саад учруулсан нь..... аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Төмөрбаатарт сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга С.Мөнхцэцэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

"СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ" ХХК-ИЙН  
АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ